



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/752 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан тендер шалгаруулалтын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тайлагнах, архивлах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Худалдан авах ажиллагаатай холбоотой жишиг баримт бичгүүд”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан загварын дагуу холбогдох баримт бичгүүдийг боловсруулж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг танилцуулан ажиллахыг Хуулийн хэлтэс /Г.Мөнхнасан/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГҮНДСАМБУУ